



ӨВӨРХЛНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 8/195

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын “Тооллогын товыг өөрчлөх тухай” 2003 оны 224 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/541 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын мал, тэжээвэр амьтдын тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 07-ноос 12 дугаар сарын 17-ны хооронд зохион байгуулсугай.
2. Мал тэжээвэр амьтдын 2022 оны тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: П.Аюушжав (Мал эмнэлэгийн тасгийн дарга, улсын байцаагч)

Э.Буяントогтох (Хөдөө аж аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Н.Батсайхан (Татварын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: Э.Дашдуулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

3. Тооллогод явах ажлын хэсэг, чиглэлийг хавсралтаар баталсугай.

4. Тооллогын ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, тогтоосон хугацаанд заавар журмын дагуу чанартай зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул), тооллогын бэлтгэл ажлыг сайтар ханган, 2022 оны 12 дугаар сарын 24-ний дотор аймгийн Статистикийн хэлтэст тайлан мэдээг нэгтгэн, хүргүүлэхийг Төсөв төрийн сангийн мэргэжилтэн (Э.Дашдуулам) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

